

## “МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО” НИЙТЛЭЛИЙН ДУРСГАЛТ БИЧИГ БОЛОХ ТУХАЙД

М. Наранчимэг\*

\* “Соёл-эрдэм” дээд сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, магистр (МА), докторант

**Түлхүүр үг:** нийтлэл, утга зохиол, дурсгалт бичиг, тэмдэглэл, мэдээ, соёл, зан заншил, өв, бичгийн зохиол, мэдээлэл, өрнөл, уламжлал, хандлага

**М**онголын хуучны утга зохиолын бичгээр олдсон анхны томоохон дурсгал болох “Монголын нууц товчоо”-г гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид Монголын ард түмний түүх, уран зохиол, хэлний дурсгал гэж үзсээр иржээ. Гэтэл уг дурсгалт бичгийн дотор өнөөгийн нийтлэлийн утга зохиолын элементүүд арвин байгааг судлан тогтоосон зүйл нэн ховор байна. Энэ нь юуны өмнө манай оронд сэтгүүл зүйн судалгаа шинжилгээ их хожуу эхэлсэнтэй холбоотой юм. Өөрөөр хэлбэл хуучны утга зохиолын дотор армаг тармаг явж ирсэн нийтлэлийн шинжтэй зүйлсийг судлах мэргэжлийн боловсон хүчин өнгөрсөн зууны жараад оны дунд үеийг хүртэл байсангүй. Энэ үеийг хүртэл сэтгүүл зүй зөвхөн бусдын боловсруулсан бэлэн загвар, үндэсний сэхээтнүүдийн монгол ухаан, авьяас мэдрэмж дээр тулгуурлан хөгжиж байлаа. Ийм шалтгаанаас болж хуучны утга зохиол төдийгүй ХХ зууны эхэн үеийн шинэ утга зохиол дахь нийтлэлийн зүйлүүд ч уран зохиолын судлагдахуун болж

хүнийссэн олон баримтыг дурдаж болно. Жишээ нь өнөөдрийг хүртэл Д. Нацагдоржийн “Майн нэгнийг хөрөнгөтний газар үзэв” гэдэг бүтээлийг өгүүллэг, “Улаанбаатараас Берлин хүртэл” гэдэг туурвилыг найраглал гэж үзэн, сургуулийн сурах бичигт хүртэл оруулчихсан байдаг. Гэтэл эдгээр бүтээлийн эхнийх нь үйл явдлын найруулал, удаах нь аян замын тэмдэглэл юм. Энэчлэн С. Буяннэмэх, Г. Навааннамжил, Ши. Аюуш, Б. Дорж зэрэг зохиолч, сэтгүүлчдийн олон бүтээл нэгэнт уран зохиолын судлагдахуун болж нийгмийн ой санамжид хадгалагдсан байдаг.

Сүүлийн үед сэтгүүлч эрдэмтдийн дундаас утга зохиол судлалд гарсан энэ өрөөсгөл хандлагыг залруулах оролдлого гарч эхэлж байгаа нь бодит үнэнийг байранд нь тавих эхлэл болж байгааг тэмдэглэвэл зохино. Энэ үйлсэд анхны шан татсан эрдэмтэн бол МУИС-ийн профессор, хэлбичгийн шинжлэх ухааны доктор Л. Норовсүрэн юм. Тэрээр “Монголын нийтлэл” гэдэг гурван боть зохиолынхоо эхний ботид хуучны уран зохиол дахь нийтлэлийн шинжтэй зүйлсийг эрэн сурвалжилж шинжилсний дотор “Монголын нууц товчоо”-г нийтлэлийн дурсгал гэдэг дүгнэлтийг анх удаа хийсэн юм. Түүний

туурвисан "Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм"-ын гурав, "Монголын нийтлэл"-ийн гурав, бүгд зургаан боть нэг сэдэвт зохиол нь өнөөгийн сэтгүүлч, судлаачид уламжлалаасаа суралцаж туурвин бүтээх, судлан шинжлэхэд үнэ цэнтэй бүтээл болсон бөгөөд, ялангуяа Монголын хуучны уран зохиол хийгээд түүх, соёл, хууль цаазын сэдэвтэй утга зохиолын доторх нийтлэлд холбогдох зүйлсийг онолын үүднээс шүүн тунгаах, шүүрдэн гаргаж ирснээрээ онцгой ач холбогдолтой болсон юм. Өөрөөр хэлбэл орчин цагийн нийтлэлийн өвийг тодруулж, өнөөгийн нийтлэлийн эх суурь аль тэртээх XIII зууны үед тавигдаж байсныг баталсанд уг цуврал бүтээлийн үнэ цэн орших юм.

Л. Норовсүрэн дээрх бүтээлдээ «Монголын нууц товчоо»-г нийтлэлийн дурсгал гэж үзэх хоёр үндэс байна гээд «энэ нь **нэгдүгээрт**: Уг зохиол бүхэлдээ буку ерөнхий агуулгаараа тухайн цаг үеийнхээ улс төрийн үйл явдал, ард түмний ахуй амьдрал, ёс заншлыг нийгмийн өргөн дэлгэц дээр тавьж үзүүлсэн, **хоёрдугаарт**: Зохиолыг бичиж туурвихдаа нийтлэлийн элементийг өргөн ашигласан явдал мөн»<sup>1</sup> гэжээ. Энэ нь «"Нууц товчоо" бол XIII зууны үед монголын их улс мандах цагт Монгол орны дотор болсон явдлуудыг чухам үнэнээр гаргаж бичсэн учраас түүхийн хосгүй баримт бичиг болжээ» гэж академич Ц. Дамдинсүрэнгийн дүгнэсэнтэй үндсэндээ тохирч байгаа юм. Тэрчлэн «болсон явдлуудыг чухам үнэнээр» бичсэн л бол тэр нь нийтлэлийн үндсэн шинж мөн. Хуучирсаар түүх болдог нь ч бас үнэн билээ. «Монголын нууц товчоо» «Их хуралдаан болж хулгана жилийн (1240) хуран (долдугаар) сард Хэрлэний хөдөө арлын Долоон болдог,

Шилхэнцэг хоёрын завсар хааны орд бууж байхад бичиж төгсөв» гэсэн номын мэдээгээр өндөрлөж байгаа нь зохиогч энэхүү бүтээлээ их үйл эхлэхэд эхэлж, дуусахад дууссаныг харуулж байна.

**Д**октор, профессор Л. Норовсүрэн бас «Монголын нэгдсэн төр улсыг байгуулж, бэхжүүлэхэд биеэр оролцож явсан тэр нэгэн бичээч ийнхүү үйл явдлын халуун мөрийг мөшгөн тэмдэглэж явсаар хөдөлбөргүй үнэн баримтын гоёмсог эрх болж хэлхэгдсэн ийм нэг алдарт бүтээлийг туурвисан нь бүхэлдээ тухайн цаг үеэ тусгасан нийтлэл зохиол болжээ» гээд «Монголын нууц товчоо»-г нийтлэлд холбогдуулж үзэх хоёр дахь үндэслэлийг *Нэгдүгээрт*: «Монголын нууц товчоо» нь эртний монголчуудын мэдээллийн харилцааны арга хэлбэрийн талаар үнэтэй мэдээллийг өгч байгаа, *Хоёрдугаарт*: XII-XIII зууны үеийн бичгийн зохиолд орчин үеийн нийтлэлийн зарим шинж агуулагдаж байсныг энэ зохиолоос мэдэж болдог, *Гуравдугаарт*: Уг зохиолоос тухайн үеийн монгол үндэстний эрхэлдэг аж ахуй, эдэлж хэрэглэдэг зүйлсийн талаарх мэдээллийг авч болж байгаа зэрэг шинжээр тодорхойлсон байдаг. Үүнээс үзвэл Л. Норовсүрэн "Монголын нууц товчоо"-нд тухайн цаг үеийн бодит үйл явдлыг тусгасан арга, нийгэмд гүйцэтгэх үүргийн талаас нь "Монголын нууц товчоо"-г нийтлэлийн шинжтэй зохиол гэж үзсэн нь илэрхий байна.

«Монголын нууц товчоо»-г нийтлэл гэж үзэх саналыг дэвшүүлсэн хоёр дахь сэтгүүлч-судлаач бол Х. Цэвлээ юм. Тэрбээр уг зохиолыг сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлийн үүднээс шинжилж, тодорхой жишээгээр өөрийн дүгнэлтийг баталсан байна. Х. Цэвлээ «Миний сэтгүүл зүй» гэдэг бүтээлдээ

«Бичгийн хэлээр дамжиж ирсэн сэтгүүл зүйн уламжлал монгол оронд олон бий, үнэн баримт, үйл явдлын энгийн хуурнал, гүн эргэцүүлэл, ярилцлага, уран тод дүрслэл зэрэг сэтгүүл зүйн үндсэн арга, төрөл зүйн ханшаар бичигдсэн "Монголын нууц товчоо"-г хүн ардыг сэнхрүүлсэн сэтгүүл зүйн бүтээл мөн байх гэж төсөөлж байна»<sup>2</sup> гээд энэ санаагаа дэлгэрүүлж «Боданчар богдын үе хүртлэх домог өгүүллийн шинжтэй удиртгалыг эс тооцвол тэнд дурдагдаж байгаа бараг бүх үйл хөдлөл нь яах аргагүй түүхэн бие хүмүүсийн хооронд, одоо хэр нь нэр хаягтайгаа үлдсэн газар оронд болсон байх бөгөөд тэмдэглэгдсэн хэрэг явдлын он цаг, жил гариг нь хүртэл зөрүүгүй зөв бичигдсэн байдлыг иш үндэс болгож байна. Хамгийн гол нь түүхчлэн өгүүлэх аргаас илүү сурвалжлан тэмдэглэх, яруу сайхан хуурна ярих арга зонхилсон, одоо үед сэтгүүл зүйн нийтлэлийн гол арга болж байгаа ярилцлагыг яг сонины ярилцлагын хэлбэрээр бичиж үлдээсэн, уран дүрслэл, зураглал, адилтгал, зүйрлэл, эргэцүүллийн зэрэг сонины бичлэгийн аргыг өргөн хэмжээгээр ашигласан зэргээс нь харахад сэтгүүл зүйн бүтээл мөн шиг надад харагддаг юм»<sup>3</sup> юм гэсэн байдаг.

**Э**нэ нь «Монголын нууц товчоо» «Өгүүлэл тэмдэглэл, ярилцлага, дурсамж, тайлан, мэдээ зэрэг орчин цагийн нийтлэлийн зүйлийг агуулж байгаа, цаг үеийнхээ үйл явдлыг үнэн бодитой, шуурхай тусгах үлгэр жишээг үзүүлж байгаа, товч бөгөөд яруу илэрхийлэх нийтлэлийн шаардлагад нийцэж байгаа, ардын аман зохиолын өвийг бичгийн зохиолд идэвхүүлэн ашиглахын бэлэн загварыг үзүүлж байгаа зэргээрээ нийтлэлийн үнэт дурсгал болох юм»<sup>4</sup> гэсэн доктор,

профессор Л. Норовсүрэнгийн дүгнэлттэй үндсэндээ дүйж байгаа юм.

Сүүлийн үеийн залуу судлаачид ч «Монголын нууц товчоо»-г нийтлэлийн дурсгал гэж үзэх хандлага ажиглагдах болов. Сэтгүүл зүйн доктор Н. Ариунзаяа «Монголын нийтлэлийн соён гэгээрүүлэгч шинж» гэдэг нэг сэдэвт зохиолдоо «Монголын нууц товчоо»-нд «Монголын бичигдэж үлдсэн зохиолын хамгийн анхны дурсгал болох энэ зохиолд юуны өмнө XII-XIII зууны үеийн Монголын нийгмийн байгууллын шинж чанар, ард түмний зан суртахуун, ахуй байдлын үнэнийг тусгасан байна»<sup>5</sup> гэж дүгнэсэн нь уг зохиол нийтлэлийн дурсгал болохыг хэлсэн хэрэг юм. Тэрээр цааш нь «Монголын нууц товчоо»-ны дотор хэдийгээр зохиолын өгүүлэмжийн хэсэг мөн боловч харьцангуй бие даасан хэлбэр, агуулга бүхий нийтлэлийн зүйлс цөөнгүй тааралдаж байгаа, уг зохиол харьцангуй утга төгссөн жижиг хэсгүүдээс бүтэх бөгөөд тэдгээр зүйлийн олонх нь ямар нэг чухал хэрэг явдлыг тоочин мэдээлсэн товч мэдээний шинжтэй байгаа зэргийг жишээ баримтаар дурдаад, Өгэдэй хаан эцгийн сууринд суугаад үйлдсэн сайн, муу явдлаа цэгнэн шинжиж байгаа хэсгийг бие даасан шинжлэлт нийтлэл гэж үзсэн байна.

Сэтгүүл зүй судлаач доктор Т. Баасансүрэн "Монголын нууц товчоо"-г нийтлэлийн дурсгал гэж үзсэн эдгээр эрдэмтдийн саналыг дэмжиж үгээ хэлсэн нь ч бий. Тэрбээр "Монголын нууц товчоо" нь зөвхөн уран зохиолын бүтээл төдийгүй, сэтгүүл зүй, нийтлэлийн шинжийг агуулсан, өөрөөр хэлбэл мэдээ, тэмдэглэл, өөрийн яриа ба өгүүлэл, ярилцлага, сурвалжлага, хөрег, аян замын тэмдэглэл зэрэгт тавигддаг шаардлагад бүрэн нийцсэн

мөчлөг, хэсэг олон байгааг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Энэхүү өгүүллийг бичигч дээр дурдсан эрдэмтдийн дүгнэлттэй санал нэгдэхийн зэрэгцээ, цаашид гүнзгий-рүүлэн судлах эрмэлзлэлтэй байгаа юм. Иймээс "Монголын нууц товчоо"-г нийтлэлийн бүтээл гэж үзэхийн тулд эхлээд "нийтлэл" гэдэг ойлголтын хүрээ хязгаарыг тогтоох хэрэгтэй гэж бодож байна. Энэ нэр томъёог утга зохиолын хүрээнд өргөн болон явцуу хоёр утгаар хэрэглэж ирсэн байна. Сонин сэтгүүлд бичиж гаргасан бүх материалыг нэлэнхүйд нь нийтлэл гэж үзэх ёс бий. Өөрөөр хэлбэл нийт олонд хүргэх, нийгэм даяар сонсох зорилгоор бичсэн юмны ерөнхий нэрийг нийтлэл гэж хэлж, бичиж заншсан байна. Энэ нь нийтлэл гэдэг үгийн өргөн утга юм. Түүнээс гадна нийтлэл гэдэг нь утга зохиолын тодорхой зүйл (жанр)-ын оноосон нэр юм. Жишээ нь сэтгүүл зүйд "уран нийтлэл" гэдэг бие даасан бичлэгийн зүйл эртнээс үүсч төлөвшсөн байна. Тийм бичлэгийг уянгын уран нийтлэл, улс төрийн уран нийтлэл гэж ангилж үзэх ёс аль хэдийнээ хэвшиж тогтсон байдаг. Энэ нь нийтлэл гэдэг үгийг явцуу утгаар нь хэрэглэж байгаагийн жишээ болно.

Гэтэл нийтэд, нийгэмд зориулсан бичлэг бүхнийг нийтлэл гэж үзэх нь бас өрөөсгөл юм. Учир нь уран зохиол, хууль цаазын бичиг зэрэг утга зохиолын тусгай төрлүүд ч гэсэн бас л нийт олонд зориулагдаж байдаг. Ингэхээр нийтлэлийг утга зохиолын бусад төрлөөс ялгах арай өөр шинжийг эрх хэрэгтэй болно. Үүний тулд юуны өмнө хоёр шинжийг онцлон үзэхэд хүрнэ. **Нэгдүгээрт:** цаг үеэ тусгаж, ажил амьдралд санаа сэдэл өгөх талаараа нийтлэл бусдаас илүү шуурхай, ажил хэрэгч, нөлөөлөх чадвар сайтай

байдаг. Өөрөөр хэлбэл хүнд шууд хүрч байгаа мэдлэг, мэдээлэл, сургаал номлол, гэгээрүүлэгч, танин мэдүүлэгч шинжтэй байх нь нийтлэлийн чухал шалгуур мөн. Ингэхийн тулд юмс үзэгдлийг бодитой тусгаж, нийгэм, цаг үедээ шууд хандаж, сайн бүхнийг дэлгэрүүлэхийг уриалах нь нийтлэлийн зорилго юм. **Хоёрдугаарт:** өгүүлэх арга маяг, нөлөөлөх чадвараараа нийтлэл утга зохиолын бусад төрөл, зүйлээс давуу байдаг. Нийтлэл бичихэд шалтгаан хэрэгтэй. Тэр нь бидний аж төрж байгаа эрин цагийн нийгэм, улс төр, эдийн засаг, соёл, зан суртахууны зэрэг олон салбарт болж байгаа үйл явдал, ололт дутагдал юм. Товчоор хэлбэл нийтлэлийг нийгмийн сайн сайхан аж амьдралын төлөө бичгээр хийх тэмцэл гэж ойлгож болно. Нийтлэл өөрчлөн шинэчлэгч, илчлэн шүүмжлэгч, соён гэгээрүүлэгч, дайчин шуурхай байж гэмээнэ энэ шаардлагыг хангаж чадна.

**О**росын эрдэмтэн В. М. Горохов утга зохиолын бусад төрөл, түүний дотор сэтгүүл зүйн мэдээллээс ялгаарч чухал нийтлэлийн шинжийг тодорхойлсон байдаг. Тэрбээр «Амьдралын тодорхой хэсгийн баримт, үйл явдалд тулгуурлан мэдээллийг нийгмийн тодорхой хэсэгт зориулан туйлын шуурхай хүргэдэг үйл ажиллагааг сэтгүүл зүй, өгүүлж буй асуудалдаа нийгэм улс төр, үзэл суртлын гүн гүнзгий дүн шинжилгээ хийж, энэ чанараараа орчин үеийн түүхийн субъектив хүчин зүйлд их анхаардаг, нийтэд зориулагдсан даацтай бүтээл туурвих үйл ажиллагааг нийтлэл зүй»<sup>6</sup> гэж тодорхойлсон байдаг. Үүнтэй нэгэн адилаар сонин хэвлэлд өдөр тутам нийтлэгдэж байдаг жижиг, шуурхай бичлэг болох мэдээ, тайлан, сурвалжлага зэрэг зүйлийг

сэтгүүл зүйн, аль нэг асуудлыг тодорхой хугацаанд гүнзгий судалж, үзэл, өрнөл, хандлагыг цогцоор нь авч үзээд өөрийн дүгнэлтийг гаргадаг, зарим тохиолдолд хэлний уран яруу хэрэглүүрийг ашиглаж, дүр дүрслэл-тэйгээр бичдэг өгүүлэл, найруулал, гэмдэглэл гэх мэт харьцангуй том хэмжээтэй, буурьтай бичлэгийг нийт-лэл гэж үзэх ёс ч бий.

Сэтгүүл зүй судлаач доктор, профессор Л. Норовсүрэн-гийн үзэж байгаагаар аливаа уран саналга, хийсвэрлэлгүйгээр үйл явдал, бодит байдлыг тусгаж, хүн ба нийг-мийн ажил үйлс, оюун санаанд мэдлэг, мэдээллийг шууд хүргэж байгаа утга зохиолын бүтээл бүхэлдээ нийт-лэлийн үүргийг гүйцэт-гэдэг аж. Энэ бүх онол дүгнэлт, үзэл баримт-лалаас үзвэл нийтлэл гэдэг ойлголт маш өргөн утгатай байна. Энэ нь ч "Монголын нууц товчоо"-г нийтлэлд хамаатуулж үзэх бидний санааг лавшруулж байгаа юм. Үүнээс үүдэн ер нь нийтлэл гэдэг утга зохиолын төрөл сэтгүүл зүй үүсэхээс өмнө байсан уу, эсвэл сонин хэвлэлтэй нэгэн зэрэг үүссэн үү? гэдэг асуудал гарч ирдэг. Энэ асуултанд судлаачид сонин сэтгүүл үүсэхээс өмнө нийтлэл байсан гэж нэгэн дуугаар харуулж иржээ.

Академик Ц. Дамдинсүрэн «Ардын шинэ соёлыг байгуулахдаа бид хуучны соёлын өвийг шалгаруулан үзэж, аль боломжтой сайн талыг нь ашиглах хэрэгтэй. Манай хуучны уран зохиол долоон зуун жилийн түүхтэй бөгөөд боломжтой сайн талын зохиол

үлэмжхэн байна. Үүнийг судлан үзэж, шинэ соёлыг байгуулахдаа ашиглах нь бидний ариун үүрэг болно»<sup>7</sup> гээд, тэрхүү өвийн дотор нийтлэлийн шинжтэй зүйл арвин байгааг ч хүлээн зөвшөөрсөн байдаг. Тухайлбал «XIII зууны үед эмээлийн дуу, элдэв хүний хэлсэн мэргэн үг, сургаал билиг, уран шүлэг, цэцэн яриа зэргийг бичиж авдаг байжээ» гэсэн нь ард түмний дунд аман ний лэлийн арвин их уламжлал байсныг хожим бичиг зохиолд буулган хэ-рэглэж эхэлснийг хэлсэн хэрэг юм.

«

*Түүхчлэн огуулах аргаас илүү сурвалжлан тэмдэглэх, яруу сайхан хүүрэн ярих арга зонхилсон, одоо үед сэтгүүл зүйн нийтлэлийн гол арга болж байгаа ярилцлагыг яг сонин ярилцлагын хэлбэрээр бичиж үлдээсэн зэргээс нь харахад сэтгүүл зүйн бүтээл мөн*

»

бичиг гэж үзэх зорилготой нэгэн юм. Тэгэхдээ өгүүлж байгаа зүйл үнэн бодитой байх, болсон явдлыг мэдээ-лэхдээ тодорхой эх сурвалжид тушиг-лэх, тэрхүү мэдээлэл нь нийгэмд хэрэг-тэй байх зэрэг нийтлэлд тавигддаг үндсэн шаардлагууд "Монголын нууц товчоо"-нд байгаа эсэхийг гол шалгуур болгож байгаа билээ. Энэ үүднээс авч үзвэл "Монголын нууц товчоо"-нд хүүрнэх, тоочих, тодорхойлох, зураг-лах, дүрслэх, эргэцүүлэх, дурсах зэрэг сэтгүүл зүйн туурвилд өргөн хэрэглэгд-дэг аргаар бичсэн хэсэг цөөнгүй байгаа юм. Хамгийн гол нь хүмүүсийн аж амьдралд зайлшгүй хэрэгтэй баримт, үйл явдлын мэдээг уламжлан дам-жуулж, тухайн нийгмийн нөхцөлд

тохирсон харилцааг буй болгож, шинэ мэдлэг, амьдралын арга ухаан сургасан шинжтэй өгүүлэмж олон байгаа нь уг бүтээлийг нийтлэлийн агуулгатай болгож байгааг мэдэж болно.

"Монголын нууц товчоо"-нд өнөгийн сэтгүүл зүйн бичлэгийн зүйлүүд бараг тэр чигээрээ байж байгааг ч харж болно. Сэтгүүл зүй судлаач Т. Баасансүрэн уг зохиолын 98 дугаар зүйлд аймшигт тайчууд ирж явааг мэдээлсэн хэсгийг орчин үеийн сонин мэдээний сонгодог загвар дээр тавьж үзээд шуурхай мэдээ мөн гэж үзжээ. Уг өгүүлэмж нь **When (Хэзээ)?** - "Өглөө үүр цайж байхад", **Where (Хаана)?** - "Хэрлэн мөрний эх Бүрги эрэг", **What (Юу)?** - "Газар дэлбэрэх мэт чимээ гарч, морьт төвөргөөн сонсогдов", **Who (Хэн)?** - "Тайчууд" гэх мэтээр<sup>8</sup> мэдээний сонгодог асуултауд яв цав хариулж байгааг нотолсонтой санал нийлэхээс өөр аргагүй байна. Мөн сэтгүүлч Х. Цэвлээ "Монголын нууц товчоо"-ны 54, 55 дугаар зүйлийг хөрөг найрууллын шинжтэй гэсэн бол, Т. Баасансүрэн сурвалжилсан тэмдэглэл, зураглалсан сурвалжлагын хэлбэртэй гэж үзсэн байдаг. Энэ мэтээр "Монголын нууц товчоо"-нд сэтгүүл зүйн бичлэгийн зүйлүүд товч мэдээнээс эхлээд сурвалжлага, тэмдэглэл хүртэл шинж тэмдгийн болон сонгодог загвараараа байгаа олон жишээ дурдаж болно.

**М**иний бодоход "Монголын нууц товчоо"-г нийтлэлийн дурсгал гэж үзэх гурван үндэслэлийг нэрлэж чадах байна. **Нэгдүгээрт:** зохиолын ерөнхий агуулга нь тухайн цаг үеийнхээ нийгэм, улс төрийн үйл явдал, ард түмний ахуй байдал, ёс заншлыг тусган харуулсан нь бүхэлдээ нийтлэлийн агуулгатай юм. Үүнийг «Сорхан-шарын гэрийн

тэмдэг нь шөнө турш үүр цайтал сүү самарч эсэг (айраг) бүлэх бүлгээ. Тэр тэмдгийг баримталж, бүлүүрийн чимээг чиглэж очоод гэрт нь орвол Сорхан-шар өгүүллүү: Чамайг эх, дүү нарын зүг яв гэж эс хэллүү би. Чи юунд ирээ гэв. Түүний хүү Чамбай Чулуун өгүүллүүн: Болжмор шувуу харцгаас дутаажбутын ёроолд хоргодвол бут түүнийг хамгаалж аварна. Одоо бидэнд хүн хоргодож ирэхэд тэгж хэлж яаж болно гэж эцгээ буруушааж, дөнгийг эвдэж галд түлээд, Тэмүүжинийг хойд унгаст хар (мухлаг) тэргэнд агуулж, амьтан хүнд бүү хэл гэж Хадаан нэртэй охин дүүгээр асруулав» гэх буюу нэгжүүлийг явсан хойно «Тэмүүжинд Сорхан-шар өгүүллүүн: Намайг үнсээр хийсгэн алдав чи. Одоо даруй эх ба дүү нарын зүг яв гэж ам цагаан эрмэг хулагч гүүг унуулж, тэлээ хургыг чанаж, хөхүүр ба нэг нум сум хоёр өгч, эмээл ба хэтгүйгээр явуулав» гэх мэтээр бичсэн нь монголчууд малынхаа ашиг шимийг хүртэж, хоол хүнснийхээ гол эх үүсвэрийг мал аж ахуйгаасаа авч байсныг, мөн нум саадаг хэрэглэж, хөхүүрт айраг эсгэж байсан зэрэг мэдээллийг агуулж байгаа нь мэдээллийн шинжтэй байна.

**Хоёрдугаарт:** "Монголын нууц товчоо"-ны өгүүлэмжид нийтлэлийн элементийг өргөн ашигласан байдал тод илэрч байна. Чингис хаан өрлөг жанжин, албат ардуудынхаа тус тусын ажил үүргийг тодорхой зааж, оногдсон үүргийг үнэнчээр биелүүлж байхыг удаа дараа сануулж байгааг илэрхийлсэн өгүүлэмж олон байна. Тухайлбал «Чингис хаан өгүүллүүн: "Бидний бие байлдаанд эс мордвол хэвтүүл биднээс ангид байлдаанд мордож үл болно" гэв. "Энэ зарлигийг мэдсээр байгаад атаархан зөрчиж, хэвтүүлийг байлдаанд мордуулбал

хэргийг эрхлэх чербийг буруушаан шийтгэнэ" гэж зарлиг болов. Хэвтүүлийн цэргийг байлдаанд үл мордуулах шалтгааныг та нар асуувал хэвтүүл миний алтан амийг сахина. Шувуу, гөрөөсийг авлахад хамт явж үлднэ. Нүүх суухад ордыг хамгаалж, явсаг тэргийг харгалзана. Миний биеийг сахиж хонох хялбар уу? Ийм давахар салбар ажилтай тул биднээс ангид байлдаанд явуулахгүй гэсэн учир "Тийм биз" гэжээ" гэх буюу «Шихихутугийн зарга шийтгэхэд хэвтүүлээс сонсолцож оролцтугай. Хэвтүүлээс нум, саадаг, хуяг, зэвийг хадгалах, түгээх ажлыг эрхлэлцтүгэй. Агт морьдыг авчирч ачаа юмыг ачиж явтугай" гэв. "Хэвтүүл, Чэрби нарын хамт эд агуурсыг түгээж байгун. Хорчин, торгууд нар нутаг заагаад нүүхэд Есөнтэй, Бүхэдэй нарын хорчин, Алчидай, Өэлэн Ахудай нарын торгуудууд ордны баруун этгээдэд явтугай" гэв. "Бухай, Додай, Чэрби, Чанай нарын торгууд ордны зүүн этгээдэд явтугай" гэв. "Бүх хишигтэн, торгууд ба ордны орчим явах орд гэрийн хөвгүүд адуучин, хоньчин, тэмээчин, үхэрчнийг ордны дараа ард явах Додай чэрби, хотол ордны хойноос дагаж, хог идэж, хомоол түүж явтугай" гэж зарлиг болов» гэсэн өгүүлэмжүүд нь өнөөгийнхөөр бол удирдлагын гаргасан шийдвэрийг ямар ч өөрчлөлтгүйгээр мэдээлсэн тайлан мэдээний шинжтэй гэж хэлж болно.

Мөн үйл явдлын тэмдэглэл хэлбэртэй зүйл ч элбэг байна. Жишээ нь «Чингис хаан Хэсивү-д буугаад дараа нь Жундугийн Шар хээрт буув. Зэв, Цавчаал боомтын хаалгыг эвдэж, тэндээс цэрэг хөдөлгөж Чингис хаанд ирж нийлэв. Алтан хаан Жундугаас зайлахдаа Жунду хотод Хада нэрт ноёныг лү-шоу гэдэг сайд болгож

орхисон ажээ. Чингис хаан Жунду балгасны алт, мөнгө, эд уурс, юмыг тоолуулахаар Үнгэр буурч, Архай Хасар, Шихихутуг гурвыг илгээв. Энэ гурвын очиход Хада ноён угтаж, алттай хээтэй эд уурсыг барьж хот дотроос гарч уулзав. Хада-д Шихихутуг өгүүллүүн: "Урьд энэ Жунду хот ба Жундугийн эд юм Алтан хааных байв. Одоо Жунду Чингис хааных болов. Чингис хааны эд уурсыг чи яагаад далдуур хулгайлан авчирч өгч байна?, үүнийг би авахгүй" гэж Шихихутуг эс авав. Үнгэр буурч, Архай Хасар хоёр авав. Энэ гурав Жундугийн юмыг тоолж ирэв. Чингис хаан Үнгэр, Архай хоёрыг маш буруушаан донгодов. Шихихутугийг "чи их ёсыг сэтгэжээ" гэж маш сайшаан соёрхож, "Чи миний үзэх нүд, сонсох чих биш үү" гэж зарлиг болов гэжээ». «Монгол хэлний тайлбар толь»-д тэмдэглэл гэдэг үгийг «Аливаа хэрэг явдлыг тэмдэглэн бичсэн дэвтэр» гэсэн байдаг. Түүнчилэн тэмдэглэлд хэд хэдэн объектийг, түүнчилэн сая болсноос эхлээд эрт болж өнгөрсөн явдлыг ч тусгаж болдог онолын үүднээс авч үзвэл дээр өгүүлсэн хэсэг яах аргагүй тэмдэглэлийн шинжтэй байна.

**Гуравдугаарт:** "Монголын нууц товчоо"-ны дотор тухайн үеийн монголчуудын эрхэлдэг аж ахуй, эдэлж хэрэглэдэг зүйлсийн талаар тов тодорхой мэдээллүүдийг өгсөн мөчлөг, хэсэг олон байна. Жишээ нь Тайчууд Өэлүн үжинийг хөвгүүдийн нь хамт нутагт гэж нүүсний дараа Өэлүн эх хөвгүүдээ тэжээх гэж юу хийж, ямар хүнс хэрэглэж байсныг «Оюунтай төрсөн Өэлүн эх Оёдолт дээлийг огшуулан өмсөж, Оготор хормойг шуун бүсэлж, Онон мөрнийг өгсөж уруудаж, Олирс мойлыг түүн явж, Өчүүхэн хөвгүүдээ хайрлан тэжээж, Өдөр шөнийг аргацаан өнгөрүүлэв» гэж

илэрхийлсэн байна. Энэ нь өнгөц харахад шүлгийн хэлбэртэй боловч Онон мөрний хөвөөнд хүнсний зээлгэ ургамал, жимс байдгийг мэдээлснээрээ нийтлэлийн агуулгатай байна. Түүнчилэн ердийн хүүрнэх, тоочих аргаар бичсэн мэдээг "Монголын нууц товчоо"-ноос олноор нь үзэж болно. Тухайлбал «Тэмүжин урьдын шивээлсэн газарт ирээд өвсний налархайгаар мөшгөн, Онон мөрөн өөд явж, өрнөөс ухсах Химурга горхинд хүрэв. Химурга горхины өөд өгсөж, Бэдэр хошууны Хорчухуй болдог гэдэг газар хүрч эх дүү нартай учрав» (МНТ. 88), «Тэнд бүгдээр нийлэлдэж, Бурхан халдуны өвөр Хүрэлх дотор урсах Сэнгүр горхины Хар зүрхний Хөх нуур гэдэг газар очиж нутаглаад тарвага, зурам алж идэн амьдрав»(МНТ. 89) гэх мэтээр бичсэн байна. Хүүрнэх хэлбэрээр бичсэн хэсэгт зохиогч гуравдугаар биеэс өгүүлсэн зүйл зонхилж байна. Мөн оруулгын тоочилт болон нэмэлт тодруулга хийх маягаар өөрөө асууж, хариу хэлэх, өөртэйгөө ярих хэлбэрээр бичсэн хэсэг ч байна. Аль аль нь нийтлэлд өргөн хэрэглэгддэг өгүүлэмжийн аргууд юм.

"Монголын нууц товчоо"-ны 91 дүгээр зүйлд «Тэмүжин тэндээс явж урьдын шивээлсэн газарт ирээд Чингис хаан тэрхүү далан нэмүргээс халх (гол) руу хөдөлж явах зуураа цэргээ бүртгэж үзвэл хоёр мянган зургаан зуун хүн байна. Үүнээс нэгэн мянган гурван зуун хүнийг Чингис хаан авч, Халх голын өрнөд этгээдээр нүүв. Нөгөө нэгэн мянган гурван зуун цэрэг Уруд мангудын хамт Халх голын дорнод этгээдээр нүүв. Тэгж нүүж явах замдаа хүнэ ололхын тулд ав хийхэд Хуйлдар шархаа эдгээгүй байтал Чингис хааны ятгасан үгийг үл сонсон, гөрөөсөнд довтолж яваад шарх үгдэрч наснаас

нөгчөв. Түүний ясыг Халх голын Орнугын Хэлтгий хад гэдэг газар орш улав» гэж байна. Нийтдээ 91 үгээс бүтсэн энэ өгүүлэмжийг сэтгүүл зүйн бичлэгт заавал тавьдаг сонгодог зургаан асуултаар сорьж үзэхэд бүрэн хариулт өгч байна.

**М**өн зохиолд орчин үеийн сонин ярилцлагын хэлбэрээр бичигдсэн, тэгэхдээ зөвхөн хэлбэрээрээ төдийгүй ямар нэг асуудлын зангилааг тайлж, ээдрээг гаргахад чиглэсэн агуулгатай хэсэг олон байна. Жишээ нь «Халх голын Буйр нуурт цутгах уулзварын газарт тэргэн эмээлтэй тэнэмэл хонгирад нутаглаж байгаа гэж сонсоод Чингис хаан өгүүллүүн: "-Эдний хонгирад эртнээс эхлэн одоо хүртэл зээгийн зүсээр, охины өнгөөр явна гэх тэдний дууллыг дурдан сануулбал дуртайяа элсэн дагах биз. Хэрэв эсэргүүцвэл байлдаж эзлэгтүн" гэж Жорчидайгаар толгойлуулан урууд иргэнийг илгээвэл хонгирад нар түүнд элсэн оржээ. Чингис хаан элсэн орсон хонгирад нарыг огт хөндсөнгүй» гэх мэтээр бичсэн байна. Хуучны утга зохиолд хоёр этгээдийн харилцан ярилцсан зүйлийг "өгүүллүүн", "өгүүлсэн нь" гэх мэт урьтал үгээр эхэлдэг уламжлалтай байсныг гэрчлэх баримт олон бий. Судлаачид "Монголын нууц товчоо"-нд элч зарж илгээсэнтэй холбоотой "элчид хэл явуулав", элчээр хэлүүлсэн нь гэх мэт тогтмол хэрэглэдэг үг хэллэг 711, хоёр хүн харилцсантай холбогдох тогтмол үг 407, зарлиг буулгасан, тушаасан зэрэгтэй холбогдох "зарлиг болов", "зарлиг болруун" гэх мэт тогтмол үг 134 байгаа<sup>9</sup>-г тогтоосон байна. Үүнээс үзвэл орчин үеийн ярилцлагын элементийг "Монголын нууц товчоо"-нд өргөн ашиглаж байжээ гэж үзэх үндэс бүрэн байгаа юм.

Түүнчилэн мэдээллийн харилцааны зөтний хэлбэрүүдийн нэг болох элч зарж мэдээ занги авалцах аргыг XIII зууны үед өргөн хэрэглэж байсныг энэ алдарт дурсгалаас харж болно.

Дээр дурдсанаас үндэслэн "Монголын нууц товчоо"-г нийтлэлийн дурсгалт бичиг гэж үзэх дараах үндэслэлийг санал болгож байна. Үүнд:

1. "Монголын нууц товчоо" XIII зууны үеийн Монголын нийгэм, улс төрийн бодит байдлыг үнэн мөнөөр нь бичиглэж үлдээсэн итгэмжит сурвалж мөн.
2. "Монголын нууц товчоо" тухайн үеийн нийгмийн аж байдал, хүн ардын эрхэлдэг аж ахуй, эд өлөгийн зүйлсийн талаарх мэдээллийн найдвартай эх сурвалж болж чаддаг.
3. "Монголын нууц товчоо" бол тухайн үеийнхээ үйл явдлын мэдээг халуун сэргэгээр нь тусгасан цагийн бичиглээс мөн.
4. "Монголын нууц товчоо"-нд орчин цагийн сэтгүүл зүйн бичлэгийн арга хэлбэрээр бичигдсэн зүйл, мөчлөг, хэсэг олон байгаа нь уг дурсгалт бичигтэй хамт өнөөгийн нийтлэлийн үр хөврөл бүрэлдэж эхэлснийг харуулах баримт мөн.
5. "Монголын нууц товчоо"-нд өнөөгийн сонин хэвлэлийн бичлэгийн эрэлт хэрэгцээтэй зүйл болох мэдээ, тайлан, тэмдэглэл, ярилцлага, хөрөг зэрэг зүйлүүд бараг өнөөгийнхөө дүр төрхөөр байгааг харж болно.
6. Энэ бүхнээс үндэслэн "Монголын нууц товчоо"-г эрин цагийнхаа түүхийг бичиж үдээсэн нийтлэлийн дурсгалт бичиг гэж үзэж байна.

### Ишлэл

<sup>1</sup> Норовсүрэн Л. 2004. "Монголын нууц товчоо" нийтлэлийн дурсгал мөн // МУИС-

- ийн ЭШБ (Сэтгүүл зүй). № 222 (21), 38 дахь тал.  
<sup>2</sup> Цэвэлээ Х. 2004. Миний сэтгүүл зүй. УБ., 41 дэх тал.  
<sup>3</sup> Мөн тэнд, 42 дахь тал.  
<sup>4</sup> Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ., 66-67 дахь тал.  
<sup>5</sup> Ариунзаяа Н. 2014. Монголын нийтлэлийн соён гэгээрүүлэгч шинж. УБ., 7 дахь тал.  
<sup>6</sup> Горохов В. М. 1975. Закономерности публицистического творчества. М., с. 12-15.  
<sup>7</sup> Дамдинсүрэн Ц. 1967. Монголын уран зохиолын өв уламжлалын асуудалд. УБ., 15 дахь тал.  
<sup>8</sup> Баасансүрэн Т. 2014. "Монголын нууц товчоо" - нийтлэлийн дурсгалт бичиг мөн. УБ., 292-293 дахь тал.  
<sup>9</sup> Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ., 60 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Норовсүрэн Л. 2004. "Монголын нууц товчоо" нийтлэлийн дурсгал мөн // МУИС-ийн ЭШБ (Сэтгүүл зүй). № 222 (21).
2. Цэвэлээ Х. 2004. Миний сэтгүүл зүй. УБ.
3. Норовсүрэн Л. 2004. 2005. 2007. Монголын нийтлэл. Тэргүүн, дэд, гутгаар дэвтэр. УБ.
4. Норовсүрэн Л. 1999. Монголын сэтгүүл зүйн өмнөх үзэгдлүүд. УБ.
5. Ариунзаяа Н. 2014. Монголын нийтлэлийн соён гэгээрүүлэгч шинж. УБ.
6. Горохов В. М. 1975. Закономерности публицистического творчества. М.
7. Дамдинсүрэн Ц. 1967. Монголын уран зохиолын өв уламжлалын асуудалд. УБ.
8. Баасансүрэн Т. 2014. "Монголын нууц товчоо" - нийтлэлийн дурсгалт бичиг мөн. УБ.

### Summary

The presentation content includes "Secret history of Mongolia" and tseese meaning expressed Mongolian social, political, mode of life and publicacation recording article, note, report, interview and news. Therefore written the information clearly, with eloquent expression on the presentation. As a result, the publication is considered to be a memorial.